

**МОНГОЛЫН БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХОЛБООНООС
“МОНГОЛБАНКНЫ ГАДААД ВАЛЮТЫН ДУУДЛАГА ХУДАЛДААНД
ОРОЛЦОХ ББСБ-УУДЫН САНАЛЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ” ЖУРАМ**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1** Банк бус санхүүгийн байгууллага /цаашид ББСБ гэх/ нь Монголын ББСБ-ын Холбоо /цаашид “Холбоо” гэх/ болон банкаар /цаашид “Банк” гэх/ дамжуулан Монголбанкнаас зохион байгуулах гадаад валютын дуудлага худалдаанд /Цаашид “Дуудлага худалдаа” гэх/ оролцохтой холбогдон гарах эрх зүйн харилцааг зохицуулна.

ХОЁР. ББСБ-Д ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 2.1** Дуудлага худалдаанд оролцох ББСБ нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- 2.1.1** Банк, ББСБ, Холбооны “Хамтран ажиллах гэрээ” байгуулсан байна.
 - 2.1.2** Банк, ББСБ, Холбооны “Хамтран ажиллах гэрээ”-ний **2.2** дугаар заалтыг хангасан, Холбооны гишүүн ББСБ байна.

ГУРАВ. ДУУДЛАГА ХУДАЛДААНД ОРОЛЦОХ САНАЛЫГ ЦУЦЛАХ

- 3.1** Энэ журмын **2.1** болон Банк, ББСБ, Холбооны “Хамтран ажиллах гэрээ”-ний **2.3** дугаар заалтыг хангаагүй ББСБ-ын аливаа саналыг дуудлага худалдааны сонгон шалгаруулалтанд хүлээн авахгүй.
- 3.2** Дуудлага худалдааны материал хүлээн авах хугацаанаас хоцорсон саналыг хүлээн авахгүй.

ДӨРӨВ. ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ

- 4.1** Дуудлага худалдааны сонгон шалгаруулалт дараах зарчмаар явагдана. Үүнд:
- 4.1.1** ББСБ нь “Хамтран ажиллах гэрээ”-ний **3.3**-д заасан материалыг дуудлага худалдаанд оролцох саналын хамт бэлтгэж дуудлага худалдаа болохын өмнөх өдрийн **14:00-16:00** цагийн хооронд Холбоонд хүргүүлнэ.
 - 4.1.2** Холбоонд ирүүлсэн саналыг гүйцэтгэх захирал хүлээн авч, баримт хүлээлцэх дэвтэр дээр саналыг хүлээн авсан цаг, минут, хүлээлгэн өгсөн, хүлээн авсан хүний гарын үсгийг зурж тэмдэглэл хөтлөнө.
 - 4.1.3** Холбооны удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, сайн дурын гишүүдийн төлөөллөөс бүрдсэн **2** хүртэлх төлөөлөгчид болон Холбооны гүйцэтгэх захирлын бүрэлдэхүүнтэй сонгон шалгаруулалт явуулах комиссыг Удирдах зөвлөлийн хурлын шийдвэрээр томилно. Сонгон шалгаруулах комиссыг гүйцэтгэх захирал удирдан явуулна.
 - 4.1.4** Сонгон шалгаруулалт явуулах комиссын бүрэлдэхүүний хувиарыг Удирдах зөвлөлийн хурлаар улирал бүрийн эхэнд батлан гаргана. Сонгон шалгаруулалт явуулах комиссын бүрэлдэхүүнд оролцох хүсэлтэй ББСБ буюу

сайн дурын гишүүд хувиар батлагдахаас өмнө хүсэлтээ Холбоонд ирүүлсэн байна.

4.1.5 Сонгон шалгаруулалт явуулах комисс саналыг нэгтгэн авч дараах зарчмаар дуудлага худалдаанд оролцох ам.доллар, юань тус бүр **5** хүртлэх саналыг шалгаруулна. Үүнд:

1. Холбоонд ирүүлсэн худалдах, худалдан авах ам.доллар, юанийн саналуудыг хамгийн өндөр ханшаас эхлэн хамгийн бага ханш хүртэл эрэмбэлж худалдан авах хамгийн өндөр, худалдан хамгийн бага ханш бүхий **5** хүртлэх ББСБ-ын саналыг сонгон шалгаруулна.
2. Санал давхцсан тохиолдолд цаг хугацааны зарчмыг баримтлана.
3. Сонгон шалгаруулалтын комисс сонгон шалгаруулах үйл ажиллагааны талаар тэмдэглэл хөтөлж, гарын үсэг зурж баталгаажуулна.
4. Сонгон шалгаруулалтанд оролцох ББСБ шимтгэлийн өр төлбөргүй байна.

4.1.6 Холбоо дуудлага худалдаанд оролцох ББСБ-уудын саналыг дуудлага худалдаа болохын өмнөх өдрийн **18:00** цагаас өмнө Банкны холбогдох ажилтанд хүргүүлснээр сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа дуусгавар болно.

4.1.7 Холбоо дуудлага худалдаанд оролцохоор шалгарсан ББСБ-уудад дуудлага худалдаа болохын өмнөх өдрийн **19.00** цагаас өмнө цахим шуудангаар мэдэгдэнэ.

ТАВ. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ШИМТГЭЛ

5.1 Холбооны сонгон шалгаруулах үйл ажиллагааны шимтгэл дараах байдалтай байна.

5.1.1 ББСБ-ын санал Монголбанкны дуудлага худалдаагаар баталгаажсан тохиолдолд худалдах/худалдан авах үйлчилгээний шимтгэл ам.долларын хувьд **10** мөнгө, юанийн хувьд **2** мөнгө байна.

5.1.2 ББСБ-ын санал Монголбанкны дуудлага худалдаагаар цуцлагдсан, хэрэгжээгүй тохиолдолд худалдах/худалдан авах үйлчилгээний шимтгэл ам.долларын хувьд **5** мөнгө, юанийн хувьд **1** мөнгө байна.

5.1.3 Шимтгэлийг дуудлага худалдаа хийгдсэнээс хойш ажлын **2** хоногт багтаан нэхэмжлэхийн дагуу Холбооны дансанд шилжүүлсэн байна.

---°°---